



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ
УЛААН ТУГИЙН ОДОНТ
**АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2020 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот

Өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн
эмнэлгийн тусламж, үйлчилгээг хангах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3, 16.5.5 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалт, Улсын онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 12 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/1516 тоот тушаалыг Арьсны өвчин судлалын үндэсний төвийн тасаг, албадын дарга, ажилчид хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай. Үүнд:

- 1.1 КОВИД-19 халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийх, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал /Т.Баярмаа/-д;
- 1.2 Бэлэн байдлын болон хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан халдвар хамгааллын дэглэм, бусад арга хэмжээнүүдийг тодотгож, 2020 оны 11 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд байгууллагын бэлэн байдлыг шалгаж, төлөвлөгөөг дахин нягталж, бэлэн байдлыг хангуулахад шаардагдах төсөв, холбогдох бусад тооцоог гаргаж шийдвэрлүүлэхийг Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал /Т.Баярмаа/-д;
- 1.3 Эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангаж, эмнэлгийн ор дэлгэх, нөөц эмнэлэг ажиллуулах бэлтгэлийг хангахыг Эмнэл зүй эрхэлсэн дэд захирал /Б.Батцэцэг/-д;

1411900419

- 1.4 Хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуур, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, хүчилтөрөгчийн хангамж, унаа шатахууны нөөцийг бүрдүүлэх Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал /Т.Баярмаа/, Санхүүгийн албаны дарга /Ш.Гантуяа/, Эм зүйн албан дарга /Э.Болорцэцэг/, тархвар судлаач /Б.Болорзаяа/ нарт;
- 1.5 Эрүүл мэндийн ажилтнуудын дархлааг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэхийг Хүний нөөцийн албаны дарга /Б.Есүхэй/, тархвар судлаач /Б.Болорзаяа/ нарт;
- 1.6 Эмнэлгийн халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр ажлыг батлагдсан зааврын дагуу камерийн хяналтанд хатуу чанд мөрдөж ажиллахыг Мэдээлэл, технологийн албаны дарга /Б.Ганзориг/, тархвар судлаач /Б.Болорзаяа/ нарт;
- 1.7 Улсын онцгой комиссын 2020 оны 4 дүгээр Албан даалгавар “Мааскаа зүүе, гараа угаая” аяныг чанартай зохион байгуулж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэл, сурталчилгааг эрчимжүүлж, эрүүл мэндийн байгууллагын нэвтрэх хэсэгт ажилчдын болон үйлчлүүлэгчдийн халууныг тогтмол хэмжиж, тэднийг мааскаа зүүх, маскгүй ажилчид, үйлчлүүлэгчдийг дотогш нэвтрүүлэхгүй байх арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанар, аюулгүй байдлын албаны даргын албан үүргийг түр хугацаанд хавсран гүйцэтгэгч /Б.Баярмаа/, нийгмийн эрүүл мэндийн ажилтан /Б.Түвшинбаатар/ нарт;
- 1.8 Хамгаалалтын хувцас өмсөх, тайлах дарааллыг тогтсон горимыг нэгбүрчлэн дагаж мөрдөх, энэ чиглэлээрх сургалтыг тогтмол явуулах, тэмдэглэгээ хийх, баримтжуулах, цахим хэлбэрээр байнга таниулах ажлыг зохион байгуулахыг нийгмийн эрүүл мэндийн ажилтан /Б.Түвшинбаатар/, тархвар судлаач /Б.Болорзаяа/ нарт;
- 1.9 Байгууллагын дотоод хөдөлгөөний урсгалыг зохицуулж, эмчлүүлэгчийн сахиур, ар гэрийн эргэлтийг хязгаарлах арга хэмжээ

авахыг Эмнэл зүй эрхэлсэн дэд захирал /Б.Батцэцэг/, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанар, аюулгүй байдлын албаны даргын албан үүргийг түр хугацаанд хавсран гүйцэтгэгч /Б.Баярмаа/ нарт;

1.10 Олон нийтийг хамарсан бүх төрлийн сургалт зохион байгуулахгүй байхыг Сургалтын албаны дарга /Ц.Сарангуа/-д;

1.11 Үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчдийн аюулгүй байдал, хувь хүний нууц, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Мэдээлэл, технологийн албаны дарга /Б.Ганзориг/, байгууллагын нууц хариуцсан ажилтан /Т.Мөнхцацрал/ нарт;

1.12 Эрсдэлт бүлгийн судалгааг байгууллагын хэмжээнд 14 хоног тутам шинэчлэн гаргаж, Эрүүл мэндийн яамад хүргүүлэхийг Хүний нөөцийн албаны дарга /Б.Есүхэй/-д тус тус үүрэг болгосугай.

2. Тушаалыг төвийн нийт ажилчдад уншиж танилцуулж, тушаалтай танилцсан тухай тэмдэглэгээ хийлгэж авахыг Хүний нөөцийн албаны дарга /Б.Есүхэй/-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэл зүй эрхэлсэн дэд захирал /Б.Батцэцэг/, Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал /Т.Баярмаа/ нарт үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Ц.УРАНЧИМЭГ

